



2019 оны 02 сарын 26

Дугаар А/116

Зууныд

Газар эзэмших эрх шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын нутаг дэвсгэрт байрлах газар эзэмших эрхийн 000703578 дугаар бүхий гэрчилгээтэй 4110061381 нэгж талбарын дугаартай Номт 1-р баг, Ирээдүй хотхон, Жаргалан хотхон, Лувсангомбын гудамж 104 тоотод гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 223 м² газар эзэмшигч иргэн Г.Сүхбаатар нь нас барсан тул 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №12 өвлөх эрхийн гэрчилгээний дагуу эхнэр Галя овогтой Оюунаа /НЭ70011461/, хамтран эзэмшигчээр Сүхбаатар овогтой Сүхжавхлан /НЭ91090317/, Сүхбаатар овогтой Сарангуа /НЭ89120501/ нарт дээрх зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар эрх шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Г.Оюунаа, С.Сүхжавхлан, С.Сарангуа нарт дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2. Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/369 дүгээр захирамж болон газар эзэмших эрхийн 000703578 дугаартай гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

01 000707